



2020 оны 04 дүгээр сарын 17  
№15 /1117/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

**Монгол Улсын Их Хурлын  
чуулганы хуралдааны дэгийн  
тухай хуульд нэмэлт  
оруулах тухай**

**Монгол Улсын  
хууль**

**Аж ахуйн нэгжийн орлогын  
албан татвараас хөнгөлөх,  
чөлөөлөх тухай**

**Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол**

**Коронавируст халдвар  
/COVID-19/-ын цар тахлын  
үед иргэдийн эрүүл мэнд,  
орлогыг хамгаалах, ажлын  
байрыг хадгалах, эдийн  
засгийг идэвхжүүлэх багц  
арга хэмжээний тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

154.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	766
155.	Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай	768
156.	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	769
157.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай	770
158.	Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай	771
159.	Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай	771
160.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	772
161.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	773
162.	Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай	773
163.	Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай	775
164.	Олон улсын гэрээний тухай хуульд нэмэлт оруулах тухай	775
165.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	776
166.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	777

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

167.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 20	777
168.	Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай	Дугаар 21	779



<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b>			
169.	Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай	Дугаар 26	783
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>			
170.	Үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 389	784
<b>МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ</b>			
2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр		Улаанбаатар хот	
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ</b>			
<p><b>1 дүгээр зүйл.</b> Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:</p> <p style="text-align: center;"><b>1/5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг:</b></p> <p>“5.5.Онц байдал, дайн бүхий болон дайны байдал, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд асуудлыг хялбаршуулсан болон цахим хуралдаанаар хэлэлцүүлж болно.”</p> <p style="text-align: center;"><b>2/6<sup>1</sup> дүгээр зүйл:</b></p> <p><b>“6<sup>1</sup> дүгээр зүйл. Цахим хуралдааны дэг</b></p> <p>6<sup>1</sup>.1. Энэ хуулийн 5.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн ирц бүрдүүлэх, санал хураалт явуулах, төсөл хэлэлцэх үе шатыг тогтоох, эцсийн найруулга сонсох болон шийдвэр хүчин төгөлдөр болох асуудлыг шуурхай хэлэлцэх талаар зарчмын зөрүүтэй санал гарсан бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж болно.</p> <p>6<sup>1</sup>.2. Энэ хуулийн 5.5-д заасан нөхцөлийн үед чуулганы хуралдааны байршлыг өөрчилж болно.</p> <p>6<sup>1</sup>.3. Нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдааныг /цаашид “хуралдаан” гэх/ цахим хуралдааны программ ашиглан зохион байгуулах бөгөөд цахим хуралдааны программ нь гишүүд, ажлын хэсэг байршлаас үл хамааран дүрсээ харан нэгэн зэрэг сонсох болон ярих боломжтой байна.</p>			

6<sup>1</sup>.4.Хуралдааны зарыг албан ёсны цахим шуудан болон холбооны хэрэгсэл ашиглан Улсын Их Хурлын гишүүнд мэдэгдэнэ.

6<sup>1</sup>.5.Гишүүн товлосон цагт цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлэн оролцох үүрэгтэй. Гишүүн үүргээ эс биелүүлбэл энэ хуулийн 10<sup>1</sup>-д заасан хариуцлага хүлээлгэх болон хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр товлосон цагт ирцэд бүртгүүлээгүй бол тухайн асуудлаар гишүүний үг хэлэх эрхийг хасна.

6<sup>1</sup>.6.Хэлэлцэх асуудлын материалыг албан ёсны цахим шуудангаар илгээж, Улсын Их Хурлын цахим хуудсанд байршуулна.

6<sup>1</sup>.7.Хуралдаанд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11.4-т заасан Зөвлөлийн гишүүд биечлэн, бусад гишүүн төрийн ордон дахь хуралдааны танхим, эсхүл албан өрөөнөөсөө оролцох бөгөөд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдсэн бол тухайн байгаа газраасаа цахим хуралдааныг хэвийн явуулах боломж, нөхцөлийг хангаж оролцоно.

6<sup>1</sup>.8.Хуралдаанд тухайн хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсэг, Улсын Их Хурлын Тамгын газрын холбогдох ажилтан оролцож болно.

6<sup>1</sup>.9.Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд цахим хуралдааны программ ашиглаж, оролцсон гишүүнийг хуралдаанд хүрэлцэн ирснээр тооцож, хуралдааны ирцэд бүртгэнэ.

6<sup>1</sup>.10.Хуралдааны ирцэд бүртгүүлсэн гишүүн тухайн хуралдаанаас албан ёсоор чөлөө аваагүй, Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудал хэлэлцсэн гэж бүртгэлээс гарахаа өөрөө мэдэгдэж, цахим хуралдаанаас гараагүй тохиолдолд түүнийг хуралдааны ирцэд тооцон тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно.

6<sup>1</sup>.11.Хуралдааны үед нам, эвслийн бүлэг тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авахаар бол хуралдаан даргалагч асуудлыг тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан завсарлагын хугацааг тогтооно.

6<sup>1</sup>.12.Улсын Их Хурлын гишүүн хуралдаанд үг хэлж, байр сууриа илэрхийлэх, тайлбар хийх, асуулт асуухдаа цахим хуралдааны программын мэдээлэл солилцох хэсэгт бичвэр томьёоллоор мэдэгдэн дараалалд орж хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр микрофон нээгдэхэд үг хэлж, асуулт асууна.

6<sup>1</sup>.13.Онцгой нөхцөлд цахимаар хуралдаж байгаа үед асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй, хариулт, тайлбар хангалтгүй гэж үзвэл тухайн гишүүний саналаар 1 удаа 1 минутаас илүүгүй хугацаагаар дахин нэмэлт асуулт асууж, тайлбар авах бөгөөд үг хэлэх хугацаа 3 минутаас илүүгүй байхаар тогтооно. Нам, эвслийн бүлэг, гишүүд шаардлагатай гэж үзвэл саналаа нэгтгэн асуулт асууж, саналаа илэрхийлж болно.



6<sup>1</sup>.14.Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар ил санал хураалт явуулах бөгөөд хуралдаан даргалагч санал хураалтын цагийг урьдчилан мэдэгдэнэ.

6<sup>1</sup>.15.Санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим хэлбэрээр явуулна. Санал хураалтын дүнг хуралдаан даргалагч нэгтгэн танилцуулна.

6<sup>1</sup>.16.Нууц санал хураалтыг зөвхөн санал хураах хуудсаар явуулна.

6<sup>1</sup>.17.Энэ хуулийн 5.5-д заасан нөхцөлд хаалттай хуралдаан явуулах дэгийг тусгайлан хуулиар зохицуулна.

6<sup>1</sup>.18.Хуралдааны дэг зөрчсөн болон цахим хуралдааны программын мэдээлэл солилцох хэсэгт хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй үг бичих, цахим хуралдааныг хэвийн явуулахад саад учруулсан үйлдэл гаргавал гишүүнд хуралдаан даргалагч сануулах, сануулга авсан гишүүн дахин зөрчил гаргавал түүний тухайн өдрийн хуралдаанд, эсхүл тухайн хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асуух, үг хэлэх эрхийг нь хасах, цахим хуралдааны программын мэдээлэл солилцох хэсэгт бичих, үг хэлэх эрхийг нь 3 цаг хүртэл хугацаагаар хасаж, энэ тухайгаа мэдэгдэнэ.

6<sup>1</sup>.19.Цахим хуралдаанд энэ хуулийн 9<sup>1</sup>.2 дахь хэсгийг баримтлахгүй.

6<sup>1</sup>.20.Хуралдааны явцыг дуу, дүрс бичлэг, мэдээллийн бусад техник хэрэгсэл ашиглан хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас бэхжүүлнэ.

6<sup>1</sup>.21.Энэ зүйлийн 6<sup>1</sup>.5-д заасны дагуу ирц, санал хураалтад оролцсон гишүүдийн саналаа илэрхийлсэн талаарх баримтыг тухайн асуудлыг хэлэлцсэн хувийн хэрэгт хавсаргана.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.3.5 дахь заалт нэмсүгэй:

“11.3.5.олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийг Засгийн газар тогтооно.”

**2 дугаар зүйл.** Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн гарчгийн “зэрэгт” гэсний дараа “болон олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.7 дахь заалтын “заасан” гэсний дараа “болон онц байдал, дайн бүхий болон дайны байдал, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хууль,” гэж, 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэгт “Онц байдал, дайн бүхий болон дайны байдал, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд 72 цагийн дотор саналаа хүргүүлнэ.” гэсэн 2 дахь өгүүлбэр тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.22 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“12.2.22. Монгол Улсын Их Хурлын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай;”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС ХӨНГӨЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлсэн албан татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан нь гэрээ болон Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан төлбөрийн баримтаар нотлогдсон тохиолдолд бууруулсан хэмжээгээр түрээсийн орлогод ногдуулах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэх бөгөөд энэ хөнгөлөлтийн хэмжээ нь тайлант хугацаанд түрээсийн орлогод ногдуулсан албан татвараас их байвал илүү гарсан хэсгийг татварын хөөн хэлэлцэх хугацаанд багтаан дараагийн тайлант хугацаанд шилжүүлэн эдэлж болно.

**2 дугаар зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон орлогод мөн хуулийн 20.1, 20.2.7-д заасны дагуу ногдуулан тайлагнасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг чөлөөлсүгэй.

**3 дугаар зүйл.** Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэх тендерт шалгарч, тус ажлыг хийж гүйцэтгэж байгаа албан татвар төлөгчийн хувьд уг ажилтай холбоотой олсон орлогод энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан чөлөөлөлт хамаарахгүй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийн 1, 2, 3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

**5 дугаар зүйл.** Албан татвар төлөгч энэ хуульд заасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахгүй байх эрхтэй.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТАТВАРЫН АЛДАНГИ, ТОРГУУЛИАС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд албан татвар төлөгчийн хуулийн дагуу ногдуулан тайлагнасан төлбөл зохих татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас тухайн албан татвар төлөгчийг нэг удаа чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Дараах орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу чөлөөлөхгүй:

2.1. төрийн албан хаагчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;

2.2. төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажилладаг хувь хүний цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;

2.3. гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэх





тендерт шалгарч, тус ажлыг хийж гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд ажилладаг хувь хүний зөвхөн уг ажилтай холбоотой олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого.

**3 дугаар зүйл.**Албан татвар төлөгч энэ хуульд заасан татварын чөлөөлөлтөд хамрагдахгүй байх эрхтэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг хэрэгжүүлэх журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан барааны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан барааны жагсаалтыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/"-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛЭЭС ЧӨЛӨӨЛӨХ, АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНГААС ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн дараах хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчаас бусад даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагч /Монгол Улсын иргэн/-ийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно:

1.1.төрийн байгууллагад ажиллаж байгаа даатгуулагч;



1.2.төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагч;

1.3.гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсний төлбөрөөс цалин хөлс авч нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөх даатгуулагч.

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан сайн дураар даатгуулсан нийгмийн даатгалын байгууллагатай мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан сайн дураар даатгуулахаар гэрээ байгуулсан Монгол Улсын иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд түүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно.

**3 дугаар зүйл.**Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгоно.

**4 дүгээр зүйл.**2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 2, 4, 5 дахь хэсэгт заасан сан хооронд хөрөнгө шилжүүлэн зарцуулж болно.

**5 дугаар зүйл.**2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, сайн дураар даатгуулсан даатгуулагч энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийн 1, 2 дугаар зүйлд заасан шимтгэлээс чөлөөлөгдөх шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн хүсэлтээр нийгмийн даатгалын шимтгэлээ төлж болно.

**7 дугаар зүйл.** Энэ хуульд заасан ажил олгогч болон даатгуулагчийн шимтгэлийг чөлөөлөх, бүртгэх, ногдуулалт хийх, тайлагнах, хяналт тавих, хэвийн үйл ажиллагаа нь алдагдсан аж ахуйн нэгж, байгууллагыг тодорхойлох, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх, нийгмийн даатгалын сан хооронд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ  
ТӨЛӨГЧИЙГ ТОРГОХ ШИЙТГЭЛ,  
АЛДАНГИАС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд ногдуулж тайлагнасан боловч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан торгох шийтгэл, мөн зүйлийн тайлбарын хоёр дахь өгүүлбэрт заасан алдангиас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Олон улсын гэрээний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг:**

“9.6.Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн, бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан байгуулах энэ хуулийн 8.1.2-т заасан хоёр талт олон улсын гэрээний саналыг тухайн



гэрээний төсөл, гэрээний орчуулга, соёрхон батлах тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлалын төслийн хамт Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.8, 20.9-д заасан зөвшөөрлийг авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.”

**2/15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг:**

“15.4.Энэ хуулийн 9.6-д заасан тохиолдолд энэ зүйлийн 15.1-д заасан Засгийн газраар хэлэлцүүлэхтэй холбоотой зохицуулалт хамаарахгүй.”

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС  
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2020 оны хаврын тариалалтад шаардагдах 15.0 /арван таван/ мянган тонн улаан буудайн элит үр, дотоодын гурил үйлдвэрлэлд шаардагдах 160.0 /нэг зуун жаран/ мянган тонн хүнсний улаан буудай, бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, элсэн чихэр, ургамлын тос импортлоход гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.**Гаалийн албан татвараас чөлөөлөх улаан буудайн элит үр, хүнсний улаан буудай, бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, элсэн чихэр, ургамлын тосны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2020 оны хаврын тариалалтад шаардагдах 15.0 /арван таван/ мянган тонн улаан буудайн элит үр, дотоодын гурил үйлдвэрлэлд шаардагдах 160.0 /нэг зуун жаран/ мянган тонн хүнсний улаан буудай, бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, элсэн чихэр, ургамлын тос импортлоход болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор дотоодод үйлдвэрлэсэн ургамлын тосыг тус тус нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх улаан буудайн элит үр, хүнсний улаан буудай, бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, элсэн чихэр, ургамлын тосны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар 20

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэг, Тагнуулын байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6, 11.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу онцгой нөхцөлд Монгол Улсын Их Хурлын нэгдсэн



болон Байнгын, дэд, түр хорооны хялбаршуулсан хуралдаан болон цахим хуралдааны аюулгүй байдлыг хангах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Тагнуулын ерөнхий газар /Д.Гэрэл/-т даалгасугай:

1/онц байдал, дайн бүхий болон дайны байдал, Гамшгийн тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд чуулганы хуралдааны байршлыг өөрчилж хуралдах шаардлагатай болсон үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах;

2/Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны цахим хуралдаанд ашиглах программ хангамж, техник, тоног төхөөрөмж болон мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;

3/цахим хуралдаан болон санал хураалтын үед системийг гадны халдлагаас сэргийлэх, кибер аюулгүй байдлыг хангах;

4/эрх хэмжээнийхээ хүрээнд холбогдох бусад байгууллага, албан тушаалтантай хамтран шаардлагатай төлөвлөгөө, журмыг баталж, хэрэгжүүлэх.

2.Монгол Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хялбаршуулсан хуралдаан болон цахим хуралдааны бэлтгэл хангах, мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Бямбацогт/, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Т.Аюурсайхан/, Тусгай хяналтын дэд хороо /С.Батболд/-нд тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар  
хот

### **Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр дараах багц арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

#### **Нэг.Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:**

1/хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж, үүнд шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвт зохицуулалт хийх, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн нэмэлт эх үүсвэр бүрдүүлэх замаар санхүүжүүлэх;

2/коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортоор оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх.

#### **Хоёр.Иргэдийн орлогыг хамгаалах чиглэлээр:**

1/Монгол Улсын иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх бөгөөд үүнд дараах орлогод ногдох хувь хүний орлогын албан татвар хамаарахгүй.Үүнд:

а/төрийн албан хаагчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;





б/төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажилладаг хувь хүний цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;

в/гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэх тендерт шалгарч, тус ажлыг хийж гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд ажилладаг хувь хүний зөвхөн уг ажилтай нь холбоотой олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого.

2/коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгох;

3/Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан сайн дураар даатгуулсан, нийгмийн даатгалын байгууллагатай мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан сайн дураар даатгуулахаар гэрээ байгуулсан Монгол Улсын иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд түүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлж, даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцох.

### **Гурав.Ажлын байрыг хадгалах чиглэлээр:**

1/коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн дараах хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчаас бусад даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагч /Монгол Улсын иргэн/-ийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын

шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно:

а/төрийн байгууллагад ажиллаж байгаа даатгуулагч;

б/төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагч;

в/гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсний төлбөрөөс цалин авч нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөх даатгуулагч.

2/Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон орлогод мөн хуулийн 20.1, 20.2.7-д заасны дагуу ногдуулан тайлагнасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг чөлөөлөх;

3/2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд ногдуулж тайлагнасан боловч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан торгох шийтгэл, мөн зүйлийн тайлбарын хоёр дахь өгүүлбэрт заасан алдангиас тус тус чөлөөлөх;

4/2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд татвар төлөгчийн хуулийн дагуу ногдуулан тайлагнасан төлбөл зохих татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас тухайн татвар төлөгчийг нэг удаа чөлөөлөх;

5/2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлсэн албан татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан нь гэрээ болон Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан төлбөрийн баримтаар нотлогдсон тохиолдолд бууруулсан хэмжээгээр түрээсийн орлогод ногдуулах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэх;



6/2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд элсэн чихэр, ургамлын тос, бүх төрлийн хүнсний будаа, 15.0 /арван таван/ мянган тонн элит үрийн улаан буудай, 160.0 /нэг зуун жаран/ мянган тонн хүнсний улаан буудайг импортлоход гаалийн болон импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх.

### **Дөрөв.Эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр:**

1/ариутгал, халдваргүйжүүлэлт, эрүүл ахуйн горимд иргэдийг эрүүл, аюулгүй орчинд үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлсэн үйлдвэр, үйлчилгээний газруудыг үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжоор хангаж ажиллах;

2/эдийн засгийг төрөлжүүлэх, дэмжих, ажлын байр бий болгох, нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээг идэвхжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, эх үүсвэр бүрдүүлэх гэрээ, хэлэлцээрийг байгуулах, түүнийг Монгол Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх;

3/дотоодын аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хийхдээ нэн тэргүүнд үндэсний үйлдвэрлэгчийг шалгаруулж байх зарчим баримтлах;

4/дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг нэвтрүүлж төр, хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчийг цахимаар ажиллах нөхцөлийг хангах, боловсролын алсын зайн сургалтын үйлчилгээг үзүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах хяналт бүхий цахим худалдааг дэмжих, импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодод үйлдвэрлэдэг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хангамжийг сайжруулах зэрэг арга хэмжээнд шаардлагатай үнэ, тарифын хөнгөлөлтийг үзүүлэх, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5/сахилга, дэг журам, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх, эдийн засгийн сөрөг үр дагавраас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх.

2.Төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан мөнгөн хөрөнгийн зохицуулалтын хүрээнд төсвийн зарлагыг эрэмбэлэн санхүүжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг оновчтой удирдан зохион байгуулах, төсвийн мөнгөн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг төрийн сангийн

нэгдсэн дансанд төвлөрүүлэн удирдаж, мөнгөн хөрөнгийн ашиглалтыг сайжруулан үр ашгийг нэмэгдүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2020 оны 03 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 26

Улаанбаатар  
хот

### **Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Дашдоржийн Мөнхөөг Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Жамсранжавын Эрдэнэчимэгийг Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн шүүгч Самандаабазарын Өлзий-Отгоныг Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус шилжүүлэн томилсугай.

2. Адил шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох болсонтой холбогдуулан шүүгч Дашдоржийн Мөнхөөг Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Жамсранжавын Эрдэнэчимэгийг Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Самандаабазарын Өлзий-Отгоныг Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 389

Улаанбаатар  
хот

### Үндэсний хөтөлбөр батлах тухай

Ахмад настны тухай хуулийн 11.1.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, гадаадын зээл, хандив, тусламжид хамруулах замаар хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хавсралтад “67. Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр” гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД**

**С.ЧИНЗОРИГ**

Засгийн газрын 2019 оны  
389 дүгээр тогтоолын хавсралт

### **АХМАД НАСТНЫ ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Ерөнхий мэдээлэл

Дэлхий дахинд ахмад настны тоо эрчимтэй нэмэгдэж байгаа талаар Дэлхийн насжилтын хяналтын индекс 2015 судалгааны тайланд дурдсан

байна. Өдгөө 60-аас дээш насны 901 сая ахмад настан байгаа нь дэлхийн нийт хүн амын 12.3 хувийг эзэлж байгаа бол 2030 онд 1.4 тэрбум (16.5 хувь), 2050 онд 2.0 тэрбум (21.5 хувь)-д хүрэх төлөвтэй байна.<sup>1</sup>

Монгол Улсын хувьд 60 ба түүнээс дээш настны хүн амын нийт хүн амд эзлэх хувь 2015 онд 6.4 хувь байсан бол 2030 онд 11.9 хувь, 2050 онд гэхэд 21.1 хувьтай тэнцэх магадлалтай байна. Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын дүнд суурилсан “Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо”-ны үр дүнд үндэслэн 55 түүнээс дээш насны хүн амын нийт хүн амд эзлэх хувийг тооцож үзэхэд 2015 онд 9.7 хувь эзэлж байсан бол 2045 онд 19.4 хувь болж, 10 шахам пунктээр нэмэгдэхээр байна.<sup>2</sup>

Хүн амын насжилт улс орнуудад нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн олон асуудлыг дагуулж байгаа учир Дэлхийн насны хяналтын индексийг тооцож байна. Энэхүү индексийг ахмад настны аж байдал, эрүүл мэнд, чадамж, орчин нөхцөл гэсэн 4 бүлэг үзүүлэлтээр тооцдог бөгөөд 2015 онд уг индекс тооцсон 96 орноос манай улс 72-т, үүний дотор аж байдлын үзүүлэлтээр 31-д, эрүүл мэндийн үзүүлэлтээр 93-т, чадамжийн үзүүлэлтээр 64-т, орчин нөхцөлийн үзүүлэлтээр 62-т орсон байна.

Түүнчлэн Монгол Улс ахмад настны аж байдлыг сайжруулах, ядуурлаас хамгаалах талаар авч хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатайг зарим судалгааны дүн сануулж байна. Тухайлбал, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлд “Нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 53.3 хувь нь тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авдаг. Ихэнх ахмад настан буюу 97 хувь нь бага тэтгэвэртэй амьдарч, амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаагаас ахмадууд тэтгэврийн зээл ихээр авч байна.”<sup>3</sup> гэж дурджээ. Мөн МОНГОЛ УЛС-ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА”-нд ахмад настны 85.5 хувь нь нэг буюу түүнээс дээш өвчнөөр өвдсөн нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад бүртгэгдсэн байна. Ахмад настануудын өвчлөлийн бараг 80 хувь нь халдварт бус өвчин байна.<sup>4</sup> гэж дурдсан байна.

<sup>1</sup> ҮСХ-ны “Ахмад настны нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа. 2018 он. Хуудас 3

<sup>2</sup> ҮСХ-ны “Ахмад настны нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа. 2018 он. Хуудас 3

<sup>3</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл. 2016 он. Хуудас 97

<sup>4</sup> АХБ-ны ““Хөгжиж буй гишүүн орнуудын ахмад настны тусламж үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх нь” МОНГОЛ УЛС-ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА. 2018 он. Хуудас 14



Монгол Улсад ахмад настнуудын боловсролын түвшин харьцангуй өндөр ч хөдөлмөр эрхлэлтийн түвшин доогуур байна. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлд дурдсанаар “Ахмад эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаанд оролцсон 576 ахмад настны 50.2 хувь нь тусгай мэргэжлийн болон дээд боловсролтой байна. Гэтэл өнөөгийн байдлаар манай улсын нийт ахмад настны 4.3 хувь нь буюу 12.7 мянган хүн хөдөлмөр эрхэлж байна. Тэдний 31.8 хувь нь ач, зээгээ буюу хүүхэд харах ажил эрхэлж байна.”<sup>5</sup> “Мөн төрийн алба болон хувийн хэвшилд ахмад настны хөдөлмөрлөх эрх зүйн орчныг нарийвчлан тодорхойлоогүйн улмаас насаар ялгаварлан гадуурхах нөхцөл байдал үүсч байгааг сануулжээ.”<sup>6</sup>

Орчин нөхцөлөөс шалтгаалсан хувь хүний аюулгүй байдал, иргэний эрх чөлөө, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай “Дэлхийн насны хяналтын индекс”-т, гэрт болон гадаад орчинд аюулгүй байдал хангагдаагүйгээс ахмад настан бэртэж гэмтэх тохиолдол их байгааг “МОНГОЛ УЛС-ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА”-нд тус тус дурджээ.

Ахмад настнуудад ээлтэй уламжлалт зан заншил, нийгмийн харилцаа холбоог улам бэхжүүлэх, ахмад настны талаар олон нийтэд эерэг ойлголт бий болгох, хувь хүний аюулгүй байдлыг хангах, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэх, гудамж талбай, зам, барилга байгууламжийг ахмад настанд ээлтэй хүртээмжтэйгээр тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн тохижуулах шаардлагатай байна.

Дээрх хэрэгцээ шаардлага, судалгааны дүнг үндэслэн тэтгэвэр барьцаалсан зээлийн хэмжээ, хугацаа, хүүг оновчтой тогтоох, ахмад настныг ядуурлаас хамгаалах бодлого, үйл ажиллагааг тэдний эрх, ашиг сонирхол, олон улсын нийтлэг чиг хандлагад нийцүүлэн шийдвэрлэх, эрүүл мэнд, эрүүл наслалтыг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг урт хугацаанд үзүүлэх, өргөжүүлэх, нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, хөдөлмөрийн хүрээний аливаа мөлжлөг, ялгаварлалтаас тэднийг ангид байлгах, орчин нөхцөлийг сайжруулах нь нэн тэргүүний зорилт болж байна.

Монгол Улс ахмад настны талаар цөөнгүй хууль тогтоомж, бодлогын баримт бичиг батлан хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд иргэд “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх зэрэгт эд, мөнгөний тусламж авах эрхтэй” гэж заасныг үндэслэн 1994 онд нийгмийн даатгалын болон халамжийн багц хуулиуд, 1996 онд Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийг баталж, 2005

<sup>5</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл. 2016 он. Хуудас 115

<sup>6</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл. 2016 он. Хуудас 93

онд Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, 2017 онд Ахмад настны тухай хууль болгон шинэчлэн найруулжээ.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас 1998 онд “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөр”, 2009 онд “Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаарх Үндэсний стратеги”, 2013 онд “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн байна. Гэсэн хэдий ч эдгээр хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийн салбар дундын зохицуулалт, үйл ажиллагааны уялдаа холбоо, судалгаа мэдээлэл, үр дүн хангалтгүй байгааг дээрх судалгааны дүн, тоо баримтууд харуулж байна.

Иймд ахмад настнуудад тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд дэлхий нийтээр баримталж байгаа насжилтын асуудлаарх бодлогын үндсэн зарчмууд, Ахмад настны тухай хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулж, нэгдсэн бодлого зохицуулалтаар хангах хүрээнд хөтөлбөрийг боловсрууллаа.

#### Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

##### 2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.1.1. Ахмад настныг нас, хүйс, арьс өнгө, боловсрол, иргэний харьяалал, үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, оюун ухаан, бие махбодийн чадвараар ялгаварлан гадуурхагдахаас ангид байх нөхцөлийг бүрдүүлж, тэдний эрхийг хүндэтгэн хамгаалахад төрийн бодлого чиглэгдэх;

2.1.2. ахмад настнууд нийгмийн бүхий л хүрээнд эрх тэгш боломжоор хангагдах;

2.1.3. Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгууд /2015-2030/, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, “Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн баримт бичигт туссан зорилт, зарчмуудтай нягт уялдах;

2.1.4. салбар дундын хамтын ажиллагааг чухалчлах, аливаа бодлого, шийдвэр гаргах, төлөвлөн хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд тэдний оролцоог хангах;

2.1.5. хөтөлбөрийн төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд салбар хоорондын уялдааг хангасан, судалгаа, баримтад үндэслэн бодит хэрэгцээнд тулгуурлах.





### Гурав. Хөтөлбөрийн зорилго

Ахмад настны аж байдлыг дээшлүүлж, ядуурлаас хамгаалах, тэднийг эрүүл урт наслуулах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг чиглүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

### Дөрөв. Хөтөлбөрийн зорилт

#### 4.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

4.1.1. ахмад настны аж байдлыг дээшлүүлж, ядуурлаас хамгаалах;

4.1.2. ахмад настны эрүүл мэнд, эрүүл насжилтыг дэмжих, урт хугацааны тусламж үйлчилгээний стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

4.1.3. ахмад настны чадамжийг дэмжих;

4.1.4. ахмад настны амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах.

#### Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Ахмад настны аж байдлыг дээшлүүлж, ядуурлаас хамгаалах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.1.1. холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн актыг хэрэгжүүлэх хүрээнд ахмад настанд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;

5.1.2. ахмад настны орлогын баталгааг хангах, ядуурлаас хамгаалах үүднээс малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчдийг тэтгэврийн даатгалд хамрагдах хувь хэмжээг нэмэгдүүлэх;

5.1.3. ахмад настны насан туршийн боловсролд хамрагдах үйл явцыг дэмжих, чадавхжуулах сургалтад хамруулах замаар шинээр орлогын эх үүсвэр бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.1.4. малчдын хөдөлмөрийн нөхцөл, амьдралын орчин, бусад хүчин зүйлсийг үндэслэн хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох эрхийг хадгалж, хамрагдалтыг нэмэгдүүлэх;

5.1.5. тэтгэвэр барьцаалсан зээлийн хугацаа, хэмжээг хязгаарлах, хүүг бууруулах замаар ахмад настны орлогыг хамгаалах;

5.1.6. хувийн сайн дурын нэмэлт тэтгэврийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх, хууль эрх зүйн орчин бүрдүүлэх;

5.1.7. ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг дэмжих;

5.1.8. аж ахуйн нэгж, байгууллагыг “Ахмадын сан” байгуулан ажиллуулахыг дэмжих, сангийн үйл ажиллагааг бэхжүүлэх;

5.1.9. хэвтрийн, хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй зэрэг зайлшгүй байнгын асаргаа шаардлагатай ахмад настны онцлог хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тусгай дэмжлэг үзүүлэх;

5.1.10. ахмад настны амьдралын чанарын судалгаа хийж, шинэ төрлийн дэмжлэг, тусалцаа, үйлчилгээ нэвтрүүлэх;

5.1.11. аймаг, нийслэл, сум, дүүргүүд ахмад настныг бие даасан орон байртай болгох, орон байрны нөхцөлийг сайжруулах арга хэмжээг дотоод нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэх, түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамруулах;

5.1.12. ахмад настны амьжиргааг дэмжих, ядуурлаас хамгаалах үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх.

5.2. Ахмад настны эрүүл мэнд, эрүүл насжилтыг дэмжих, урт хугацааны тусламж үйлчилгээний стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.2.1. эрүүл насжилт, ахмад настны эрүүл мэндийг дэмжихтэй холбогдуулан хууль эрх зүйн орчны үнэлгээ хийх, холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн актыг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

5.2.2. Монгол хүний насжилт, ахмад настны эрүүл мэндийн талаарх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлж, мэдээллийн нэгдсэн сан бий болгох;

5.2.3. ахмад настанд зонхилон тохиолддог өвчний үед зайлшгүй хэрэглэх эмийн нэр төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

5.2.4. ахмад настныг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, шаардлагатай ахмадуудыг эмчилгээ, сувилгаанд хамруулах ажлыг эрүүл мэндийн төвөөр дамжуулан хэрэгжүүлэх, ахмад настанд гэрээр үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх, чанарыг сайжруулах;

5.2.5. хэвтрийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй ахмадуудын судалгааг жил бүр нарийвчлан гаргаж, хяналтад авах, гэрээр эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх;

5.2.6. ахмад настны эрэлт, хэрэгцээнд суурилсан урт хугацааны олон талт тусламж үйлчилгээг өргөжүүлж хөгжүүлэх, дэвшилтэд технологи, сайн туршлагыг нэвтрүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх;



5.2.7. урт хугацаанд үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, чанар стандартыг боловсронгуй болгох, хяналт үнэлгээг сайжруулах;

5.2.8. Гэрээр болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн хөдөлмөрийн үнэлэмж, нийгмийн хамгааллын асуудлыг судалж шийдвэрлэх;

5.2.9. ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхыг нэмэгдүүлэх, асаргаа, сувилгааны чиглэлээр сургалтад хамруулах, мэргэшүүлэх, тэдэнд зориулсан зөвлөгөө, дэмжлэг тусалцааг өргөжүүлэх;

5.2.10. урт хугацааны тусламж үйлчилгээний санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх, асаргааны даатгалын эрх зүйн орчин бий болгох;

5.2.11. түншлэл, хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоонд түшиглэн өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох замаар ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний сүлжээ бий болгох;

5.2.12. холбогдох хууль тогтоомж, бусад эрхийн актыг хэрэгжүүлэх хүрээнд төрөлжсөн асрамжийн үйлчилгээний шинэчлэлийн хөтөлбөр батлуулж, ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

5.2.13. ахмад настанд тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын нэр, төрлийг олшруулж, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох;

5.2.14. ахмадуудыг нас, бие бялдрын онцлогт тохирсон сургалт, чийрэгжүүлэлт, дасгал хөдөлгөөнд хамруулах.

5.3. Ахмад настны чадамжийг дэмжих зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.3.1. холбогдох хууль тогтоомж, эрхийн актыг хэрэгжүүлэх хүрээнд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх;

5.3.2. ахмад настан хөдөлмөрлөх явцад ялгаварлалт, мөлжлөгт өртөж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хөдөлмөрийн ялгаварлалт, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр ажил олгогч, үйлдвэрчний эвлэл болон хөдөлмөрийн байцаагчдын чадавхыг бэхжүүлэх;

5.3.3. ахмад настны бүтээмж, мэргэшлийн ур чадварыг үнэлэх, тэдний дунд ажил, мэргэжлийн уралдаан зохион байгуулах, мэргэшил, ур чадварыг залууст эзэмшүүлэх зэргээр ахмад настны хөдөлмөрийн бүтээмж, чадамжийн талаарх нийгмийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд нөлөөлөх;

5.3.4. гэр бүлийн өвчтэй гишүүнийг асрах, ач зээгээ өсгөн хүмүүжүүлэх зэрэг ахмад настны эрхэлж байгаа хөлсгүй хөдөлмөрийг үнэлэмжтэй болгох чиглэлээр судалгаа хийх, санал боловсруулах;

5.3.5. Төрийн захиргааны төв байгууллага бүр өөрийн салбарын хэмжээнд зөвлөх мэргэжилтнээр ажиллах мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ахмад настны бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж, тэднийг мэргэжил, мэргэшлийн чиглэлээр шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд оролцуулах, салбарын албан хаагчдыг чадавхжуулахад зөвлөх, сургагч багшаар ажиллуулах;

5.3.6. Төрийн захиргааны төв байгууллага бүр төрийн бодлого, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хянах ажиллагаанд ахмад зөвлөхүүдийг мэргэжлийн чиглэлээр оролцуулах, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүдтэй ахмад зөвлөхүүдийг танилцуулах, тэдний санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгах;

5.3.7. Төрийн захиргааны төв байгууллага бүр салбарын ахмад ажилтнуудын зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг, онол-практикийн бага хурал зохион байгуулах замаар ахмад болон залуу үеийн залгамж холбоог хангах;

5.3.8. нутгийн захиргааны байгууллага нь ахмад настны дунд биеийн тамир, спорт, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөө, шаардагдах хөрөнгийг жил бүр баталж, төсөвт тусган, хэрэгжилтийг зохион байгуулах;

5.3.9. ахмад настны спортын баг, соёл, урлагийн хамтлаг, сонирхлын бүлэг, клубыг байгуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

5.3.10. ахмад настанд зориулан чөлөөт цагийн танхим, өргөө, мэдээллийн төв байгуулж, мэдээллийг амаар, бичгээр, цахимаар, дуут болон дүрс бичлэг зэрэг олон хэлбэрээр авах боломжийг өргөжүүлэх;

5.3.11. чөлөөт цагийн танхим, мэдээллийн төв, албан бус (насан туршийн боловсролын төвөөр дамжуулан ахмад настныг бичиг үсэгт сургах, боловсролын түвшин ахиулах, компьютер, гар утас, интернет, шинэ дэвшилтэд технологи, тоног төхөөрөмж ашиглах зэрэг) зайлшгүй хэрэгцээт сургалтуудыг тэдний хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах;



5.3.12. ахмад настан, түүний гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүй, хууль эрх зүй, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн зэрэг шаардлагатай зөвлөгөө мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгуулах.

5.4. Ахмад настны амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.4.1. эцэг, эх, ахмадаа хүндлэх, асран хамгаалах соёл, хүмүүжил, уламжлалт ёс заншлыг хүүхэд залуучуудад эзэмшүүлэхэд туслах гарын авлага, аудио болон видео хичээл, материал бэлтгэх, хүртээмжийг нэмэгдүүлэх;

5.4.2. эцэг, эх, ахмад настантай хамт амьдарч, асарч тэтгэж байгаа гэр бүлд дэмжлэг туслалцаа үзүүлэх асуудлыг судлан бодлогоор дэмжих;

5.4.3. гэр бүлийн гишүүдэд өгөх зөвлөгөө, мэдээллийг өргөжүүлэх;

5.4.4. угийн бичиг хөтлөх, ургийн баяр зохион байгуулахыг дэмжиж, удам дамжин нутаг орондоо нэр хүндтэй яваа гэр бүлүүдийг жишээ болгон сурталчлах, алдаршуулах;

5.4.5. ахмад настныг хүндлэх, дэмжиж туслах эцэг, эхээ асран тэтгэх үр хүүхдийн үүрэг хариуцлагыг хүүхдэд бага наснаас нь ойлгуулах ажлыг боловсролын салбараар дамжуулан зохион байгуулах;

5.4.6. коллеж, их, дээд сургуулийн хүмүүнлэгийн ухааны хичээлийн агуулгад насжилтын асуудлыг тусгах;

5.4.7. ахмад настныг ажилд авахдаа ажлын байран дээр, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахгүй байх ёс зүйг хөдөлмөрийн хамт олны дунд төлөвшүүлэх;

5.4.8. ахмад настны ажил хөдөлмөрийн амжилт, түүхэн гавьяа, залууст үлгэр дуурайл болох үйлсийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах;

5.4.9. ажил олгогч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн болон тэтгэвэр тогтоолгож байгаа ахмад настан /ажилтан/-ыг нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;

5.4.10. тухайн ажилтан тэтгэвэрт гарсны дараа аж ахуй болон хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй бол бизнесийн болон ур чадварын сургалтад, сургагч багш зөвлөхөөр ажиллах бол сургагч багш бэлтгэх сургалтад хамруулах, дахин чадавхжуулах сургалтыг ажил олгогч зохион байгуулах;

5.4.11. тэтгэвэрт гарч байгаа ажилтны ажлын амжилтыг үнэлэх, амьдралын замнал, амжилт бүтээлийн талаар сурталчлах, хөдөлмөр алдрыг тэмдэглэх, хамт олноороо хүндэтгэлтэй үдэх зэрэг хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах;

5.4.12. ахмад настанд орон сууцыг эрх тэгш хуваарилах, тэдний өвөрмөц хэрэгцээнд зориулан орон сууцыг тоноглож тохижуулах, хүртээмжтэй дэд бүтцийг бий болгох, үр хүүхэд, асран хамгаалагчтайгаа ойр дөхөм байх бололцоог хангах;

5.4.13. улс, орон нутгийн төсөв, дотоодын бусад эх үүсвэр, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр баригдаж байгаа орон сууцны тодорхой хувийг ахмад настанд олгох, сууцны нөхцөлөө сайжруулахад зориулж байх;

5.4.14. орон сууц, гудамж, талбайн нэр, хаяг, дугаарыг стандартын дагуу бичиж байрлуулах, ахмад настны өвөрмөц хэрэгцээнд нийцүүлж өөрчлөх;

5.4.15. хот, суурин газрын явган хүний зам, нийтийн эзэмшлийн талбайн эвдрэл гэмтлийг засах, халтиргаа гулгааг арилгах, ахмад настанд тохиромжтой сандал сүүдрэвч зэргийг байршуулах;

5.4.16. зам талбайн гарц, уулзвар, барилга, байгууламжийн үүд, шат, хонгилыг ахмад настанд ээлтэй аюулгүй, хүртээмжтэй, стандартын дагуу шинэчлэн сайжруулах, хуучин барилгуудад тэдний өвөрмөц хэрэгцээнд тохирсон нэмэлт хэрэгсэл, төхөөрөмж суурилуулах;

5.4.17. ахмад настныг нутаг дэвсгэр, захиргааны харьяалал харгалзахгүйгээр хот доторх нийтийн тээврээр үнэ төлбөргүй үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх;

5.4.18. нийтийн тээврийн хэрэгсэл, үйлчилгээний орчин нөхцөлийг ахмад настны өвөрмөц хэрэгцээнд тохиромжтой, хүртээмжтэйгээр өөрчилж шинэчлэх;

5.4.19. насны хяналтын үндэсний индекс тооцох арга зүйг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн боловсруулж нэвтрүүлэх;

5.4.20. насжилтын талаарх мэдээлэл судалгааг өргөжүүлж, насны хяналтын индекс тооцоход шаардагдах мэдээллийн санг бий болгох.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

6.1. Хөтөлбөрийг 2020-2023 онд хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

7.1.1. Ахмад настны аж байдалд эерэг өөрчлөлт гарна;



- 7.1.2. Ахмад настны эрүүл насжилт, урт наслалт нэмэгдэнэ;
- 7.1.3. Ахмад настны чадамжийн үзүүлэлт сайжирна;
- 7.1.4. Ахмад настны амьдрах орчин, нөхцөл сайжирна.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин		Эх сурвалж, хэрэгжүүлэх байгууллага
			Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт	
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт							
Зорилго: Ахмад настны аж байдлыг дээшлүүлж, ядуурлаас хамгаалах, тэднийг эрүүл урт наслуулах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг чиглүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.							
1.	Дундаж наслалт	хувь	2018	70.19	2023	72.0	ҮСХ, Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, бүтэн жилийн тайлан
2.	60 наснаас дээш амьдрах дундаж хугацаа	жил	2017	16.0	2023	16.3	ҮСХ, Хүн амын статистик
3.	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55-59 нас	тоо	2018	45.9	2023	50.0	ҮСХ, Ажиллах хүчний судалгаа (1212)
4.	Орон сууцанд амьдардаг ахмад настны тоо	хувь	2019	28	2023	33.0	ҮСХ.
5.	Нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрт хамрагдсан тэтгэврийн насны хүн амын эзлэх хувь	хувь	2017	97.5	2023	100.0	ҮСХ, Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдийн тоон мэдээлэл
6.	Ахмад настан тэргүүлэгчтэй өрхийн орлого	мян/төг	2017	753,690	2023	900.000	ҮСХ, Ахмад настны нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа
7.	60 наснаас дээш эрүүл амьдрах дундаж хугацаа	жил	2017	12.1	2023	12.4	ҮСХ, Хүн амын статистик



8.	Урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх асаргаа сувилгаа/ өдөр өнжүүлэх цогцолбор төв	Цогцолбор төв	2019	0	2023	3	ХХҮЕГ-ын тайлан мэдээ
9.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдсан ахмад настан (давхардсан тоогоор)	Хүн	2018	3.1 сая	2023	4.0 сая	ҮСХ, Ахмад настны нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа
10.	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдсан ахмад настны нийт ахмад настанд эзлэх хувь (Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, санхүүгийн дэмжлэг)	хувь	2018	0,52	2023	1.5	ХХҮЕГ-ын тайлан мэдээ
11.	Ажилгүйдлийн түвшин 55-59 нас	хувь	2018	5.5	2023	5.0	ҮСХ, Ажиллах хүчний судалгаа (1212)
12.	Ахмадын хөгжлийн ордон, өргөө, танхим, төвөөр үйлчлүүлсэн ахмад настан (давхардсан тоогоор)	тоо	2018	201,000	2023	300.000	Монголын ахмадын холбооны тайлан мэдээ
13.	ГБХЗХГ-ын харьяа Хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн ахмад настан (давхардсан тоогоор)	хувь	2018	45,4	2023	60.0	ГБХЗХГ-ын тайлан





14.	Тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан ахмад настны тоо	хүн	2018	0	2023	20.000	Монголын ахмадын холбооны тайлан мэдээ
-----	---	-----	------	---	------	--------	--

### Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

9.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 9.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 9.1.2. гадаадын зээл, тусламж, хандив;
- 9.1.3. бусад эх үүсвэр.

Арав. Хөтөлбөрийн зохион байгуулалт,  
хяналт-шинжилгээ, үнэлгээ

10.1. Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулна.

10.2. Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

10.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Үндэсний хэмжээнд зохион байгуулах, салбар дундын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих, төрийн болон иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах үүргийг хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

#### Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-дүүгүд, Төрийн ордон дүү тоот  
И-мэйл: turiin\_medecelel@parliament.mn

Утас: ᠒᠒᠒᠒᠒᠒

Хэвлэлийн хуудас: ᠒

Индекс: 200003